

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын
төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: АГГ-2022/16-ШТА-ГА

Чойбалсан хот 2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэлийн тоёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ А. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.....	6
A.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тогтолцоо бүрдээгүй байна.....	6
A.1.1. Нийт төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.....	6
A.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих жагсаалтад батлагдсан ТАХ-г байгууллагын санал, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.....	7
A.1.3 ТАХ-ны ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэн эрэмбэлэх тогтолцоо бүрэлдээгүй байна.....	
A.2. Төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна.....	8
A.2.1. Шинээр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний зураг, төслийг жагсаалт батлагдсанаас хойш боловсруулж, батлуулсан байна.....	8
A.2.2. Төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжээгүй 1 төсөл, арга хэмжээ байна.....	9
A.2.3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 1.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн төсөвт ангилагдаагүй бусад зардалд батлагдсан байна.....	10
БҮЛЭГ Б. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	11
B.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулсан ч нийт шалгарсан гүйцэтгэгчийн 9.5 хувь нь шаардлага хангаагүй байна.....	11
B.1.1. Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн 21 төсөл, арга хэмжээнээс эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	11
B.1.2. Тайлант онд 1 ТАХ-г бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулаагүй байна.....	11
B.1.3. Ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ч нийт шалгарсан гүйцэтгэгчийн 9.5 хувь нь шаардлага хангаагүй байна.....	12
B.1.4. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан боловч, Шилэн дансны хууль журамд заасны дагуу цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна.....	13
B.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг хангалттай хэмжээнд зохион байгуулаагүй байна.....	14
B.2.1. Гэрээний хугацаанд дуусаагүй 1, ашиглах явцад эвдрэл гэмтэл үүссэн 1 төсөл, арга хэмжээ байна.....	15
B.2.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.....	16
B.2.3. Захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байна.....	16
B.2.4. Хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авсан байна.....	16
B.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна.....	16
B.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.....	16
B.3.2. Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 17.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж огт ашиглагдахгүй байна.....	17
B.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.....	17
Холбогдох байгууллагын санал:.....	18
Саналд өгсөн тайлбар:.....	19
ДҮГНЭЛТ:	19
САНАЛ:	20
ЗӨВЛӨМЖ:	20
ТУШААЛ:	21

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АУЗН	Аймгийн Улаан загалмайн нийгэмлэг
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн төсөл, арга хэмжээнд байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн мэдээлэл	8
Хүснэгт 2	ТАХ-ний төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх шинжилгээ	12
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний ХАА-нд мөрдсөн хугацаа	13
Хүснэгт 4	Төсөл, арга хэмжээний ХАА-ны арга, зарлагдсан ил тод байдал	14
Хүснэгт 5	Гэрээний хугацаанд дуусаагүй, хэтэрч хүлээлгэж өгсөн ТАХ	15
Хүснэгт 6	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	20

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн дунд, богино хугацааны бодлого баримт бичигт туссан, 2021 оны хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын бус ТАХ-ны харьцаа /Нийт 2.2 тэрбум төгрөг/	10

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ. Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хуралд болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх; • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Орон нутагт 2021 оны 21 төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн аудитыг хийлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6827-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийг тус тус ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.
	Аудитын дэд төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 28-ны дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайлан, холбогдох судалгааг 4 дүгээр сарын 29-ний дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

БҮЛЭГ А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөгүй байна.

А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тогтолцоо бүрдээгүй байна.

А.1.1. Нийт төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 5 дугаар зорилгын хүрээнд 5.1.1-д “Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүг төлөвлөн хэрэгжүүлнэ.” гэж тусгасан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн төсөл, арга хэмжээнүүд нь Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд 3.8.2.2¹, 2.4.1.3², 2.4.1.4³, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 2.4.2⁴, 6.2.5⁵, 2.6.8⁶, 2.8.8⁷, Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 6.1.7⁸ гэсэн заалтуудад үндэслэн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигт уялдуулан төлөвлөсөн байна.

А.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих жагсаалтад батлагдсан ТАХ-г байгууллагын санал, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3⁹ дахь заалтын дагуу захиалагчдын саналд үндэслэсэн байх шаардлагатай.

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 21 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээний саналыг орон нутгийн холбогдох төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

¹ Улс, орон нутгийн төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлнэ.

² Манлайбаатар Дамдинсүрэнгийн онголсон газрын баганыг сэргээн засварлана.

³ Маршал Х.Чойбалсангийн мэндэлсэн газарт ёслол хүндэтгэлийн цогцолбор байгуулна.

⁴ Аймгийн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийг барих, засварлах, шаардлагатай тоног төхөөрөмж, үзмэр шинэчлэх, сумдад орон нутаг судлах танхим шинээр бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулна.

⁵ Чойбалсан хотын нийтийн орон сууцны байруудын гадна фасадыг шинэчлэх, суурийг хүчитгэн бэхлэх дулаалах ажлыг хэрэгжүүлнэ.

⁶ Хүүхэд хамгааллын чиглэлээр чиглэлээр төрийн бус байгууллага, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

⁷ Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтыг ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

⁸ Төр захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын барилгын засвар, автомашины парк шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.

⁹ энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх;

Хүснэгт 1. “Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн төсөл, арга хэмжээнд байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн мэдээлэл”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мян.төгрөг)	Хүсэлт ирүүлсэн эсэх
1	Төр, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа байрны дээвэр, сантехникийн засвар	55,000.0	АЗДТГ өөрөө захиалагч байгууллага
2	Цэцэрлэгийн барилгын гадна засварын ажил /Хэрлэн сум 14-р цэцэрлэг/	61,900.0	АИТХ дээр хурлын төлөөлөгчдөөс оруулсан санал.
3	Хан-Уул сургуулийн барилгын их засвар	60,000.0	Боловсрол, соёл урлагийн газраас аймгийн орон нутгийн төсвийн болон хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналын жагсаалтад тусгагдсан байна. Мөн аймгийн Засаг даргад АИТХ-ын төлөөлөгч П.Гэрэлбаатар 2020.11.20-ны 03 тоот албан тоотойр саналыг хүргүүлсэн байна.
4	Чойбалсангийн хөшөө сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх /Аймгийн музей/	12,500.0	Аймгийн Засаг даргад Дорнод аймгийн музейн захирлын 2020.08.31-ны өдрийн 54 тоот албан бичгээр материалын төсвийг ирүүлсэн байна.
5	Нийтийн орон сууцны барилгын засвар /Хэрлэн сум, 1 дүгээр баг, 12 айлын орон сууц/	40,000.0	Аймгийн Засаг даргад АИТХ-ын төлөөлөгч Т.Төмөрбаатар 2020.11.19-ны 01 тоот албан тоотойр саналаар хүргүүлсэн байна.
6	"Зүүн бүсийн ҮЖИН төв"-ийн барилгын их засварын ажил	34,993.5	ГБХЗХГ-ын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 153 дугаартай албан бичгээр хүсэлт ирүүлсэн.
7	Орон нутгийн өмчийн газар, Халхгол, Баянтүмэн, Чойбалсан сумдын ЗДТГ-ын автомашин засвар парк шинэчлэл	174,500.0	Аймгийн ХОХБТХ-ийн даргад Чойбалсан сумын ЗД-ын 2020.05.26-ны өдрийн 1/189 тоот албан бичгийн хавсралтын жагсаалтад тусгагдсан байна.
8	Төр, нутгийн захиргааны байгууллагын автомашины парк шинэчлэлт, засвар	116,400.0	АЗДТГ өөрөө захиалагч байгууллага
9	Монгол улсын Улаан загалмайн Дорнод аймаг дахь Үндэсний хүмүүнлэгийн байгууллагад авто машины авахад дэмжлэг	37,000.0	АУЗН-н 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 46 дугаар албан бичгээр хүсэлт ирүүлсэн.
10	Орон нутгийн өмчийн газар тоног төхөөрөмж худалдан авах	10,000.0	Захиалагчаас ирүүлсэн хүсэлт, албан тоот байхгүй.
11	Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил	199,456.7	Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 1/258 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу тусгагдсан байна.
12	Чойбалсан суманд ахмад дайчдын дурсгалын хөшөө	10,000.0	АЗДТГ Манлайбаатар Дамдинсүрэнгийн 100 жилийн ойд зориулан бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн ажил.
13	Манлайбаатарын онголсон газрын дурсгалын хөшөө барих	10,000.0	
14	Цэцэрлэгийн барилгын гадна фасадын засвар /Хэрлэн сум, 3 дугаар цэцэрлэг/	8,000.0	АИТХ дээр хурлын төлөөлөгчдөөс оруулсан санал.
Нийт дүн		829,750.2	
1	Асфальт бетон авто замын засвар арчлалт /Хэрлэн сум/	80,065.4	АЗДТГ өөрөө захиалагч байгууллага. Автозамын сангаас хийгдсэн засвар арчлалт
2	Сайжруулсан болон шороон замын засвар арчлалт /Хэрлэн сум/	79,842.6	
3	Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт /Баян-Уул Эрэн даваа/	40,000.0	
4	Гүүрийн 2 талын шороон замын далангийн засвар /Хөлөнбуйр сум/	37,000.0	Аймгийн Засаг даргад Хөлөнбуйр сумын ЗД-ын 2020.11.24-ний өдрийн 1/391 тоот албан бичгээр зураг төсөв, ажлын даалгаврын хамтаар ирүүлсэн байна.
5	Чойбалсан хотоос сумдын чиглэлийн авто замын тэмдэг, тэмдэглэгээ хийх	20,000.0	АЗДТГ өөрөө захиалагч байгууллага. Автозамын сангаас хийгдсэн засвар арчлалт
6	Хэрлэн голын дунд модон гүүрний засвар /Хэрлэн сум/	10,000.0	
7	Хэрлэнгийн доод төмөр бетон болон дунд модон гүүрүүдэд автомат хаалт суурилуулах	7,250.0	
Нийт дүн		274,158.0	

Эх сурвалж: Аудиторын судалгаа, шинжилгээ /ОНӨГ-ын 2022.03.11-ны судалгаанаас /

Харин 1 төсөл, арга хэмжээнд ирүүлсэн хүсэлт байхгүй байна. Энэ нь “Орон нутгийн өмчийн газар тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээнд олгогдсон 10.0 сая төгрөгийн ажил байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 99,9 хувь нь байгууллагаас ирүүлсэн саналын дагуу байна.

А.1.3 ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэн эрэмбэлэх тогтолцоо бүрэлдээгүй байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1-т “төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх,” гэж заасан боловч,

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”- нь зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хамаарахаар заасан байна.

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг олон нийтэд танилцуулан санал авч эрэмбэлдэг үйл ажиллагааны журам батлагдан гараагүйтэй холбоотой байна. Үүнтэй холбоотойгоор 2021 оны орон нутгийн төсөл, арга хэмжээний ач холбогдлыг эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэх боломжгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-г олон нийтийн саналд үндэслэн эрэмбэлэх аргачлал, заавар журам байхгүй.

А.2. Төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна.

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний зураг, төслийг жагсаалт батлагдсанаас хойш боловсруулж, батлуулсан байна.

Төсөл, арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6¹⁰, 29 дүгээр зүйлийн 29.4¹¹, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1¹², 40 дүгээр зүйлийн 40.2¹³-т зааснаар барилга, байгууламж, түүний их засварын ажлыг гүйцэтгэхдээ зураг төсөл, ажлын даалгаврыг урьдчилан боловсруулж батлуулсан байх, газрын зөвшөөрөл, бусад техникийн нөхцөл олгогдсон байхыг тусгайлан зааж өгсөн байна.

1. Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд зураг, төсөл боловсруулах шаардлагатай 520.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ байгаагаас төсөв батлагдсанаас хойш зураг, төсөв батлагдсан 201.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ байна.

2. Батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь барилга, байгууламжийн шугам, сүлжээ, дээврийн болон гадна, дотор засварын ажлууд, авто замын засвар, арчлалттай холбоотой учраас зургийн даалгавар, газрын болон бусад зөвшөөрлүүд шаардлагагүй байна.

Хүснэгт 2. “ТАХ-ний төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх талаарх шинжилгээ”

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	ТАХ-ний жагсаалт батлагдсан огноо	Зураг, төсөв батлагдсан огноо	Зургийн даалгавар батлагдсан огноо	Газрын зөвшөөрөл олгогдсон огноо
2021 онд шинээр хэрэгжүүлсэн ТАХ						
1	“Х.Чойбалсан хөшөөг сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх” Дорнод аймаг, Хэрлэн сум	12.0	2021.06.11	2020.11.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
2	“Манлайбаатарын онголсон газрын дурсгалын хөшөө барих”	20.0	2021.06.11	2020.12.11	Шаардлагагүй	Шаардлагагүй
3	“Зүүн бүсийн Үжин төв”-ийн барилгын их засварын ажил”	34.9	2020.12.04	2020.11.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
4	Нийтийн орон сууцны барилгын засвар /Хэрлэн сум, 1 дүгээр	40.0	2020.12.04	2020.12.25	Шаардлагагүй	Шаардлагагүй

¹⁰ 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.”

¹¹ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹² 12.1. Барилгын зураг төсөл дараах шаардлагыг хангасан байна:

12.1.6. Барилгын зураг төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх

¹³ 40.2. Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

5	баг, 12 айлын орон сууц/ "Төр, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа байрны дээвэр, сантехникийн засвар/"	55.0	2020.12.04	2020.11.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
6	"Хан-Уул" сургуулийн барилгын их засвар	60.0	2020.12.04	2020.12.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
7	Цэцэрлэгийн барилгын гадна засварын ажил /Хэрлэн сум 14-р цэцэрлэг	61.9	2020.12.04	2020.12.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
2021 оны авто замын сан						
1	Сайжруулсан болон шороон замын засвар, арчлалт /Хэрлэн сум, 2-р баг/	79.8	2020.12.04	2020.11.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
2	Төв замын асфальто бетон хучилтын засварын ажил	80.1	2020.12.04	2020.11.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
3	Гүүрийн хоёр талын шороон зам далангийн засвар /Дорнод, Хөлөнбуйр сум/	37.0	2020.12.04	2020.11.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
4	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт /Баян-Уул сум, Эрээн даваа/	40.0	2020.12.04	2020.12.25	Шаардлагагүй	Шаардлагагүй
НИЙТ		520.7				

Эх сурвалж: ТАХ-ны төлөвлөлтийн судалгаа /ГХБХБГ-ын 2022.3.11/

Зураг, төсвийг төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдсанаас хойш боловсруулж, батлуулж байгаа нь хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байгаа бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа оройтож зарлагдах, улмаар тайлант хугацаанд хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

А.2.2. Төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжээгүй 1 төсөл, арга хэмжээ байна.

Батлагдсан 21 төсөл, арга хэмжээний хувьд 50 сая хүртэлх төсөвт өртөгтэй 13, 51-100 сая хүртэлх төсөвт өртөгтэй 5, 101-ээс дээш сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2020 оны 05, 04, 2021 оны 5/02, 6/03 дугаар тогтоолоор баталсан байна.

Үүнээс 2021 онд хэрэгжиж дууссан 20, гэрээний хугацаандаа хэрэгжээгүй 199.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил" байна. Энэ ажил нь улсын төсвийн хөрөнгөөр 2020-2021 онд хэрэгжиж дуусаагүй "Эрүүл мэндийн төвийн барилга"-ын ажилд гадна шугам сүлжээ, зогсоол, холбоо дохиоллын төсөв тусгагдаагүйгээс шалтгаалсан байна. Орон нутгийн хувьд нэн тэргүүний салбар учир хөрөнгө, оруулалтыг үр дүнтэй болгох үүднээс төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна. Гэвч төсвийн тухай нэмэлт өөрчлөлтөөр тухайн төсөл, арга хэмжээ 6 дугаар сард батлагдан тендерийг 7-8 саруудад, гэрээг 9 дүгээр сарын 08-ны өдрөөс байгуулсан нь дулааны улиралд гүйцэтгэж дуусах боломжгүй болсон байна.

Энэхүү тогтоолоор шинээр 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг ("Чойбалсан суманд ахмад дайчдын дурсгалын хөшөө /10.0 сая төгрөг/", "Цэцэрлэгийн барилгын гадна фасадын засвар - Хэрлэн сум 3 дугаар цэцэрлэг" /8.0 сая төгрөг/") Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а.¹⁴ дэх заалтад нийцсэн гэж үзэн нэмж баталж, хэрэгжүүлсэн байна.

¹⁴ 6.2.6.а.тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх;


Цаашид шинэ хэрэгжих төсөл, арга хэмжээг төсөвт нэмж батлахгүй байх шаардлагатай байна.

А.2.3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 1.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн төсөвт ангилагдаагүй бусад зардалд батлагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д "Хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1-д "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх" гэснийг үндэслэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг боловсруулж, батлуулах хуулийн заалттай байна.

Аймгийн ИТХ-ын 2020, 2021 оны 4 удаагийн хурлаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын бус, авто замын сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2,261.9 сая төгрөгийг баталж, үүнээс барилга, байгууламжийн засвар, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, авто замын сангийн 21 төсөл, арга хэмжээнд 1,089.3 сая төгрөгийг, хөтөлбөр, Төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой буюу хөрөнгө оруулалтын бус арга хэмжээнд 1,172.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталжээ.

Дүрслэл 1. "Аймгийн дунд, богино хугацааны бодлого баримт бичигт туссан, 2021 оны хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын бус ТАХ-ны харьцаа /Нийт 2.2 тэрбум төгрөг/"



Эх сурвалж: аймгийн ИТХ-ын 2020 оны 05, 04, 2021 оны 5/02, 6/03 дугаар тогтоолын хавсралт.

Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудаар хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг зардлыг ямар ангилалд батлах талаар зохицуулалт байхгүй байгаатай холбоотой байна.

Иймд цаашид орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг орон нутгийн төсөвт хэрхэн төлөвлөж, батлах талаар хууль, журмын зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна.

Б.1. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1. Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн 21 төсөл, арга хэмжээнээс эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Орон нутгийн төсвөөр 2021 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд холбогдох төсвийн захирагч нарт шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.1.2. Тайлант онд 1 ТАХ-г бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих төсөл арга хэмжээний 80.9 хувийг буюу 17 төсөл, арга хэмжээг АИТХ-ын 2020 оны 05 дугаар тогтоолоор, 19.1 хувь буюу 4 төсөл, арга хэмжээг тодотголоор буюу АИТХ-ын 2021 оны 05/02 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Хүснэгт 3. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний ХАА-нд мөрдсөн хугацаа”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мян.төг)	Тендерт оролцогчдын тоо	Тендер шалгаруулалт зохион байгуулсан удаа	Төлөвлөсөн огноо	Эрх олгосон огноо	Үүнээс, хэтэрсэн хугацаа
1	Төр, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа байрны дээвэр, сантехникийн засвар	55,000.0	1	6	2021/02/20	2021/06/23	-123
2	Цэцэрлэгийн барилгын гадна засварын ажил /Хэрлэн сум 14-р цэцэрлэг/	61,900.0	4	5	2021/02/20	2021/06/15	-115
3	Хан-Уул сургуулийн барилгын их засвар	60,000.0	2	3	2021/02/20	2021/05/20	-89
4	Чойбалсангийн хөшөө сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх /Аймгийн музей/	12,500.0	1	3	2021/03/01	2021/07/24	-145
5	Нийтийн орон сууцны барилгын засвар /Хэрлэн сум, 1 дүгээр баг, 12 айлын орон сууц/	40,000.0	2	1	2021/02/20	2021/03/15	-23
6	"Зүүн бүсийн ҮЖИН төв"-ийн барилгын их засварын ажил	34,993.5	1	8	2021/02/20	2021/09/13	-205
7	Орон нутгийн өмчийн газар, Халхгол, Баянтүмэн, Чойбалсан сумдын ЗДТГазарын автомашин засвар парк шинэчлэл	174,500.0	3	1	2021/03/01	2021/03/30	-29
8	Төр, нутгийн захиргааны байгууллагын автомашины парк шинэчлэлт, засвар	116,400.0	5	3	2021/03/01	2021/03/30	-29
9	Монгол улсын Улаан загалмайн Дорнод аймаг дахь Үндэсний хүмүүнлэгийн байгууллагад авто машины авахад дэмжлэг	37,000.0	1	1	2021/02/20	2021/03/12	-20
10	Орон нутгийн өмчийн газар тоног төхөөрөмж худалдан авах	10,000.0	-	-	2021/01/10	2021/03/11	-297
11	Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил	199,456.7	1	1	-	2021/08/24	-
12	Чойбалсан суманд ахмад дайчдын дурсгалын хөшөө	10,000.0	-	-	-	2021/07/19	-
13	Манлайбаатарын онголсон газрын дурсгалын хөшөө барих	10,000.0	-	-	-	2021/09/07	-
14	Цэцэрлэгийн барилгын гадна фасадын засвар /Хэрлэн сум, 3 дугаар цэцэрлэг/	8,000.0	-	-	-	-	-
Нийт дүн		829,750.2					
1	Асфальт бетон авто замын засвар	80,065.40	1	2	2021/07/05	2021/08/12	-38

	арчлалт /Хэрлэн сум/						
2	Сайжруулсан болон шороон замын засвар арчлалт /Хэрлэн сум/	79,842.60	1	1	2021/07/05	2021/07/08	-3
3	Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт/ Баян-Уул Эрээн даваа/	40,000.00	1	3	2021/08/20	2021/10/12	-53
4	Гүүрийн 2 талын шороон замын далангийн засвар /Хөлөнбуйр сум/	37,000.00	1	1	2021/07/15	2021/07/08	7
5	Чойбалсан хотоос сумдын чиглэлийн авто замын тэмдэг, тэмдэглэгээ хийх	20,000.00	1	1	2021/07/05	2021/09/08	-65
6	Хэрлэн голын дунд модон гүүрний засвар /Хэрлэн сум/	10,000.0	1	1	-	2021/06/21	-
7	Хэрлэнгийн доод төмөр бетон болон дунд модон гүүрүүдэд автомат хаалт суурилуулах	7,250.00	1	1	-	2021/04/19	-
Нийт дүн		274,158.0					

Эх сурвалж: Аудиторын судалгаа /ОНӨГ-ын 2022.3.11-ний судалгаанаас /

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн ажлуудын ХАА-г төлөвлөгөөнд тусгасан хугацаанд зохион байгуулж ажилласан боловч тендерт оролцох аж ахуйн нэгж байхгүйгээс ХАА амжилтгүй болж дахин зарласантай холбоотойгоор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хувьд 3-297 хоногоор хэтэрсэн байна.

Нийт 21 төсөл арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 20 төсөл арга хэмжээ байна. Харин 1 төсөл, арга хэмжээ болох “Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил” бүрэн хэрэгжиж дуусаагүй байна. Уг төслийн хувьд тодотголоор төсөвт тусгагдсан байна.

ТАХ-г төсвийн жилийн дундуур нэмж тодотголоор баталснаас гүйцэтгэлийн хугацаа хоцорсон байна.

Б.1.3. Ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ч нийт шалгарсан гүйцэтгэгчийн 9.5 хувь нь шаардлага хангаагүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2021 онд шинээр хэрэгжсэн 21 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим болон уламжлалт хэлбэрээр зохион байгуулснаас цахимаар 13, уламжлалтаар 8 байна.

Хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалттай холбоотой 2 ТАХ-нд гомдол гарч, 2 төсөл, арга хэмжээний хувьд ХАА-г дахин хийснээр тус төсөл, арга хэмжээнүүд нь 89 болон 115 хоногоор хоцорч гэрээ байгуулагдсан байна. Тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотойгоор ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулаагүй байна.

Харин оролцогчоос гомдол ирсэн 2 төсөл, арга хэмжээний хувьд Сангийн яамнаас ирсэн гомдол хянасан тухайд “тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТӨӨЗ. 1.1¹⁵-д заасан заалтад нийцэхгүй байсан тул захиалагчийн гэрээ байгуулах эрхийг олгосон шийдвэрийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1¹⁶ дэх заалтад үндэслэн хүчингүй болгож дахин зарлах болсон байна. Энэ нь тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаатай холбоотойгоор ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан гэж үзэх үндэслэл бүрдэхгүй байна.

¹⁵ гэрээг гүйцэтгэхэд дараах инженер техникийн ажилтнуудыг байлгах шаардлагатай. Тэдгээрийн сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, нийгмийн даатгалын цахим лавлагааг ажилтан тус бүрээр, нийгмийн даатгалын шимтгэл төлж буй ажилтнуудын жагсаалт бүхий тооцооны хуудас/сүүлийн 6 сарын байдлаар/-ын хуулбарыг ирүүлнэ.

¹⁶ энэ хуулийг зөрчсөн захиалагчийн үйлдэл буюу шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөх;

Хүснэгт 4. “Төсөл, арга хэмжээний ХАА-ны арга, зарлагдсан ил тод байдал.”

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тендерийн бичиг баримтад тусгасан шаардлагууд	Ил тод байдал
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт				
1	Төр, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж байгаа байрны дээвэр, сантехникийн засвар	55,000.0	Харьцуулалт	Цахим
2	Цэцэрлэгийн барилгын гадна засварын ажил /Хэрлэн сум 14-р цэцэрлэг/	61,900.0	Харьцуулалт	Цахим
3	Хан-Уул сургуулийн барилгын их засвар	60,000.0	Харьцуулалт	Цахим
4	Чойбалсангийн хөшөө сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх /Аймгийн музей/	12,500.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
5	Нийтийн орон сууцны барилгын засвар /Хэрлэн сум, 1 дүгээр баг, 12 айлын орон сууц/	40,000.0	Харьцуулалт	Цахим
6	"Зүүн бүсийн УЖИН төв"-ийн барилгын их засварын ажил	34,993.5	Харьцуулалт	Цахим
7	Орон нутгийн өмчийн газар, Халхгол, Баянтүмэн, Чойбалсан сумдын ЗДТГ-ын автомашин засвар парк шинэчлэл	174,500.0	Нээлттэй тендер шалгаруулалт	Цахим
8	Төр, нутгийн захиргааны байгууллагын автомашины парк шинэчлэлт, засвар	116,400.0	Нээлттэй тендер шалгаруулалт	Цахим
9	Монгол улсын Улаан загалмайн Дорнод аймаг дахь Үндэсний хүмүүнлэгийн байгууллагад авто машины авахад дэмжлэг	37,000.0	Харьцуулалт	Цахим
10	Орон нутгийн өмчийн газар тоног төхөөрөмж худалдан авах	10,000.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
11	Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил	199,456.7	Нээлттэй тендер шалгаруулалт	Цахим
12	Чойбалсан суманд ахмад дайчдын дурсгалын хөшөө	10,000.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
13	Манлайбаатарын онголсон газрын дурсгалын хөшөө барих	10,000.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
14	Цэцэрлэгийн барилгын гадна фасадын засвар /Хэрлэн сум, 3 дугаар цэцэрлэг/	8,000.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
Нийт дүн		829,750.2		
Авто замын сан				
1	Асфальт бетон авто замын засвар арчлалт /Хэрлэн сум/	80,065.4	Харьцуулалт	Цахим
2	Сайжруулсан болон шороон замын засвар арчлалт /Хэрлэн сум/	79,842.6	Харьцуулалт	Цахим
3	Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт/ Баян-Уул Эрэн даваа/	40,000.0	Харьцуулалт	Цахим
4	Гүүрийн 2 талын шороон замын далангийн засвар /Хөлөнбуйр сум/	37,000.0	Харьцуулалт	Цахим
5	Чойбалсан хотоос сумдын чиглэлийн авто замын тэмдэг, тэмдэглэгээ хийх	20,000.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
6	Хэрлэн голын дунд модон гүүрний засвар /Хэрлэн сум/	10,000.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
7	Хэрлэнгийн доод төмөр бетон болон дунд модон гүүрүүдэд автомат хаалт суурилуулах	7,250.0	Шууд худалдан авалт	Уламжлалт
Нийт дүн		274,158.0		

Эх сурвалж: Аудиторын судалгаа /ОНӨГ-ын судалгаанаас/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын нөхцөлийн хувьд харьцуулалтын аргаар 10, шууд худалдан авалтаар 8, нээлттэй тендер шалгаруулалтаар 3, нийт 21 төсөл, арга хэмжээнд ХАА зохион байгуулж ажилласан байна. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.” гэж зааснаар 3 нээлттэй тендер шалгаруулалтад тавигдсан урилгыг мэдээлсэн байна. Мөн төсөл, арга хэмжээнд оролцогчдод тендерийн мэдэгдлүүдийг үндэслэлтэйгээр тусгаж мэдэгдэл хүргүүлсэн байна.

Б.1.4. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан боловч, Шилэн дансны хууль журамд заасны дагуу цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна.

ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, тайлагнасан эсэхийг үзэхэд орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.5¹⁷-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/93 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Дээрх журмын дагуу аймгийн ТЭЗ улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь Сангийн яамд тайлагнасан боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлээгүй байна. ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагыг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн болно.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг хангалттай зохион байгуулаагүй байна.

Б.2.1. Гэрээний хугацаанд дуусаагүй 1, ашиглах явцад эвдрэл гэмтэл үүссэн 1 төсөл, арга хэмжээ байна.

Барилгын тухай хуулийн 40.2¹⁸, Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1¹⁹, 350.1.4²⁰, 350.1.7-д заасан болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэгч нь зураг, төслийн дагуу ажил, үйлчилгээг хугацаанд нь буюу чанартай гүйцэтгэх, ашиглалтын явцад үр дүнгийн доголдлыг арилгахаар заасан байна. Харин гэрээний хугацаа, чанар, ашиглалттай холбоотой дараах зөрчлүүд илэрч байна.

Гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй дараах ажил байна.

Хүснэгт №5. “Гэрээний хугацаанд дуусаагүй, хэтэрч хүлээлгэж өгсөн ТАХ”

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэтэрсэн хоног /актын огноо/	Гүйцэтгэгч компани	Тайлбар, шалтгаан
1	Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил	199.5	Дуусаагүй	“Түрүү гарав” ХХК	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц 76 хувьтай байна.

Эх сурвалж: Аудиторын судалгаа /Гэрээний хэрэгжилтийн судалгаа-АЗДТГ/

“Түрүү гарав” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын явц 76 хувьтай байгаа нь аймгийн ИТХ-ын 2021 оны 6 дугаар сарын ээлжит хурлаар тухайн төсөл, арга хэмжээ нэмж батлагдан, тендер, ажил гүйцэтгэх гэрээг 7-9 дүгээр сард зохион байгуулсантай холбоотой байна.

Аудитын явцад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэж, шалгахад ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүссэн дараах ажил байна. Үүнд:

1. ТАХ-ний нэр: “Хэрлэнгийн доод төмөр бетон болон дунд модон гүүрүүдэд автомат хаалт суурилуулах”

Төсөвт өртөг: 7.25 сая төгрөг

Гүйцэтгэгч: “Элит хөшиг” ХХК

¹⁷ Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

¹⁸ 40.2.Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

¹⁹ 350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

²⁰ 350.1.4.ажил гүйцэтгүүлэхээр захиалагчаас олгосон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах;
350.1.7.ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг /ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс г.м/ хариуцах;



Хэрэгжилт: Хэрлэн голын доод төмөр бетон болон дунд модон гүүрүүдэд хийгдсэн автомашин тусгаарлах зориулалт бүхий автомат хаалт нь ашиглах явцад хугарч, гэмтэн ашиглалтын шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 2 барилгын дээврийн засвар, 2 цэцэрлэгийн гадна засвар, 2 орон сууцны их засвар, 1 барилгын шугам сүлжээний ажил хийгдэж, 7 чиглэлийн авто замын засвар, арчлалт, 3 хөшөө, дурсгал болон засвар, арчлалт, 1 газарт тоног төхөөрөмж, 8 газарт автомашин нийлүүлэгдсэн байна.

Үүнээс “Эрүүл мэндийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил” /199.5 сая төгрөг/ гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй нь орон нутгийн төсвийн тодотголоор тус ажлыг шинээр нэмж батлан, тендер, ажил гүйцэтгэх гэрээг тухайн онд хэрэгжиж дуусах нөхцөлийг бүрэн хангаагүйтэй холбоотой байна.

Ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл үүссэн тоног, төхөөрөмжийг Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.7-г үндэслэн гүйцэтгэгч байгууллагаар гэрээний баталгаат хугацаанд засварлуулах шаардлага үүссэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



2 барилгын дээврийн засвар /АЗДТГ, “Хан-Уул” цогцолбор сургууль/



2 цэцэрлэгийн барилгын гадна засвар /14-р цэцэрлэг, 3-р цэцэрлэг/



2 барилга, орон сууцны их засвар /“Үжин” төв, Бунхны 12 айлын орон сууц/



7 чиглэлийн автозам, гүүрний засвар арчлалт /2-р багш сайжруулсан шороон зам, Төв замын асфальт, Модон гүүрний арчлалт, Баян-Уул сумын Эрээн даваа, Зүүн бетон болон модон гүүрний автомат хаалт, Хэрлэн-Халхгол чиглэлийн замын тэмдэг, Хөлөнбуйр бетон гүүрний замын арчлалт/



3 хөшөө, дурсгал /Чойбалсангийн хөшөө, Манлайбаатарын хөшөө, Ахмад дайчдын хөшөө/



1 газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Орон нутгийн өмчийн газар/



8 газрын автомашин, түүний сэлбэг хэрэгсэл /Аймгийн ЗДТГ, ИТХ, ЭМГ, ОНӨГ, Халхгол, Баянтүмэн, Чойбалсан, Улаан загалмайн хороо/

Б.2.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12-д “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.” гэж заасны дагуу захиалагч байгууллагатай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Б.2.3. Захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.4²¹, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4.3.1²²-д заасныг үндэслэн захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн байна.

Б.2.4. Хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4²³, 3.6²⁴, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.10²⁵, 5.2.9²⁶-д заасан захиалагч, зохиогчийн хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажилласнаар хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд үр дүнтэй хийгдсэн байна.

Б.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна.

Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.

Аймгийн ЗДТГ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох ёстой.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо тухайн төсөл, арга хэмжээг хянаж баталгаажуулсан гүйцэтгэлийн баримт, захиалагчийн болон зураг төсөл

²¹ 3.4.Захиалагч барилгын ажлын явц, үе шатанд тавих хяналтыг гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдтэй хамтран гэрээний үндсэн дээр өдөр, сар, улирал бүрээр гүйцэтгэнэ.

²² 4.3.1.илэрсэн зөрчил, гэмтэл, түүний шалтгаан, арилгах арга зам, засварлах хугацааг заах;

²³ 3.1.4. Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

²⁴ 3.6.Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.

²⁵ 3.10.Зохиогчийн хяналтын дүгнэлтэд дурдагдсан зөрчил дутагдлыг арилгах талаар заавар зөвлөмжийг өгч, өмнөх хяналтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгасан талаар захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчээс тайлан гаргуулна.

²⁶ 5.2.9.Зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай бүртгэлийг Хавсралт № 1-ийн Хүснэгт 9-ийн дагуу тэмдэглэнэ.

зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримт материал, хүлээн авсан комиссын дүгнэлт зэргийг үндэслэсэн байна.

Б.3.2. Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 17.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүрэн ашиглагдахгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн их засварын 10 ажил, 8 байгууллагад нийлүүлэгдсэн машин, тоног төхөөрөмжийг хүлээн авсан холбогдох байгууллагууд нь санхүүгийн бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

Орон нутгийн өмчийн газарт 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн боловч ашиглахгүй, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст эд хөрөнгийн ашиглалтын гэрээгээр хүлээлгэн өгсөн байна.

Аудитын явцад орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд ажиглалт, тулган баталгаажуулалт хийхэд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжүүд нь ашиглагдахгүй, тус байгууллагын агуулахад байна.

Мөн Хэрлэн сумын доод бетон гүүр болон дунд модон гүүрэнд хийгдсэн 7.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомат хаалт нь эвдрэл гэмтэл үүссэний улмаас бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.

Б.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх онд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад зөрчлийг арилгуулахаар өгсөн 6 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг аймгийн Засаг даргын Тамгын газраас 2021.11.08-ны өдрийн 6/2185 тоот албан бичгээр ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт болон аудитын мөрөөр хяналт тавьж үзэхэд албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

Хүснэгт 6. "Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт"

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	хэрэгжилт	Тоо	Хэрэгжилт	Тоо	Хэрэгжилт
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	9	9	6	6	3	3

Эх сурвалж: Газрын 2021 оны жилийн эцсийн акт, албан шаардлагын мэдээ, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын 2021.11.08-ны өдрийн 6/2185 тоот албан бичиг

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

Холбоо. ОН. 27 № 1/991
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг хүргүүлж байна.

Тайлангийн төслийн А.2.2 дахь хэсэгт тусгагдсан “Эрүүл мэндийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 7 дугаар баг” төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй нь тухайн төсөл, арга хэмжээг орон нутгийн төсөвт тодотгол хийж, нэмэгдүүлнээс шалтгаалсан байна гэсэн асуудлын тухайд:

“Эрүүл мэндийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 7 дугаар баг” төсөл арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа бөгөөд гадна зогсоол, гадна инженерийн шугам сүлжээ, холбоо, дохиоллын төсөв дутуу батлагдсанаас тус барилга байгууламж ашиглалтад бүрэн орох боломжгүй нөхцөл байдал үүссэн. Иймд тус төсөл, арга хэмжээг бүрэн ашиглалтад оруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхээр төсөвт өөрчлөлт оруулж батлуулсан.

Тус өөрчлөлтийг хийхдээ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6 /а/-д “тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх” гэсэн заалтын дагуу орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нийт дүнг өөрчлөхгүй байх зарчимд нийцүүлэн, тус эх үүсвэр доторх зарим төсөл, арга хэмжээний дүнг бууруулсан эх үүсвэрээс санхүүжүүлэхээр батлуулсан болно.

Иймд дээрх асуудлыг судалж үзээд тайлангийн төсөлд өөрчлөлт оруулж өгнө үү.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ч.ТАНБАТ

010522401

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Тайланд өгсөн тайлбарын дагуу аудитын дүгнэлт, зөвлөмж хэсэгт өөрчлөлтийг тусгав.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- А.1.1. Нийт төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.
- А.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих жагсаалтад батлагдсан ТАХ-г байгууллагын санал хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.
- А.1.3 ТАХ-ны ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэн эрэмбэлэх тогтолцоо бүрэлдээгүй байна.
- А.2.1. Шинээр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний зураг, төслийг жагсаалт батлагдсанаас хойш боловсруулж, батлуулсан байна.
- А.2.2. Төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжээгүй 1 төсөл, арга хэмжээ байна.
- А.2.3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 1.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн төсөвт ангилагдаагүй бусад зардалд батлагдсан байна.
- Б.1.1. Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдсэн 21 төсөл, арга хэмжээнээс эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.
- Б.1.2. Тайлант онд 1 ТАХ-г бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулаагүй байна.
- Б.1.3. Ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ч нийт шалгарсан гүйцэтгэгчийн 9.5 хувь нь шаардлага хангаагүй байна.
- Б.1.4. ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.
- Б.2.1. Гэрээний хугацаанд дуусаагүй 1, ашиглах явцад эвдрэл гэмтэл үүссэн 1 төсөл, арга хэмжээ байна.
- Б.2.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.
- Б.2.3. Захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байна.
- Б.2.4. Хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авсан байна.
- Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.
- Б.3.2. Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 17.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүрэн ашиглагдахгүй байна.
- Б.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Аудитаар нийт 6 зөвлөмж, нэгтгэсэн тайланд тусгуулах 3 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

А.1.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх журмыг боловсруулж, батлах талаар холбогдох газарт уламжлах.

А.2.3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг орон нутгийн төсөвт хэрхэн төлөвлөж, батлах талаар хууль, журмын зохицуулалт бий болгох талаар холбогдох газарт уламжлах.

Нэмэлт санал: Аймгийн 2021 оны төсвийн төслийн санал дүгнэлтээр орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг 389.0 сая төгрөг буюу 5 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын бус зардлыг 560.4 сая төгрөгөөр буюу 26 төсөл, арга хэмжээг хасах саналыг гаргаж, санал, дүгнэлтийн хэрэгжилт төсөл, арга хэмжээгээр 38.7, мөнгөн дүнгээр 35.2 хувийн хэрэгжилттэй байна. Иймд хэрэгжилтийг хангуулах талаар хууль, журмыг зохицуулалтыг бий болгох.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөр болон Засаг дарга М.Бадамсүрэнд:

А.1.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх журмыг боловсруулж, батлах талаар холбогдох газарт уламжилж, шийдвэрлүүлэх.

А.2.1. Хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлуулахаас өмнө Төсвийн тухай хуулийн 29.4, 40.2-т заасныг үндэслэн зураг, төсөл нь иж бүрэн, төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулах. /201.9 сая төгрөг/

А.2.2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а, 34 дүгээр зүйлийн 34.2.3-ыг баримтлан тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өөрчлөлт оруулж, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахгүй байх. /18.0 сая төгрөг/

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

Б.2.1. Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтыг үндэслэн Хэрлэн голын доод бетон гүүр болон дунд модон гүүрүүдэд тавигдсан автомат хаалтын ашиглалтыг сайжруулж, гэрээний баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар засварлуулах.

Б.1.3. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад гомдол гарсан үнэлгээний хороодын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Б.3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг сайжруулах. /17.2 сая төгрөг/

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 8

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Я.Зоригт даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010003

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn